

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 3 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Гадаад харилцааны яам /ГХЯ/-ны 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг яамны удирдлагад танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-т хүргүүлж байна.

Тайланд Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн биелэлт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт, Шилэн дансны хөтлөлт зэрэг журамд заасан үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг дүгнэж биелэлтийн хувь, үнэлгээг тусгав.

Дээр дурдсан журмын 9.1.1-д заасны дагуу ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн тухай 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13/304 тоот албан бичиг /хавсралт-1/, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт /хавсралт-2/, Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан /хавсралт-3/, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /хавсралт-4/, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт /хавсралт-5/, Хэрэглэгчийн үнэлгээний тайланг /хавсралт-6/ тус тус гарган хүргүүлж байна.

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем

(www.unelgee.gov.mn)-д ГХЯ-ны чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль, Улсын Их Хурал /УИХ/-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг хяналтад авсан нийт 10 төрлийн 162 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 227 зүйл, заалтын биелэлтийг оруулсан.

Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар нэгдсэн системд оруулж тайлагнахад ЗГХЭГ-аас 87.4 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн бөгөөд холбогдох тайлан, мэдээг яамны газар, нэгж, Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчдийн газар /ДТГ/-уудад хүргүүлж, биелэлт хангалтгүй байгаа буюу 30.0 хувийн үнэлгээтэй заалтуудын хэрэгжилтэнд анхаарч ажилласны үр дүнд биелэлтийн дундаж үнэлгээ жилийн эцсийн байдлаар дээшилсэн үзүүлэлттэй гарлаа.

2019 оны байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 227 зүйл заалтаас **169** заалт 100.0, **43** заалт 70.0 хувийн гүйцэтгэлтэй буюу **15** заалт үнэлгээ өгөх боломжгүй/хугацаа болоогүй, хэрэгжилтийн дундажийг **93.92** хувийн гүйцэтгэлтэйгээр 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 13/216 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн хувь доогуур гарсан заалтуудын шалтгаан, нөхцөлийг тодорхойлж оны сүүлийн хагас жилийн хугацаанд яамны газар, нэгжүүдэд заавар чиглэл, холбогдох зөвлөмжийг тогтмол өгч, гүйцэтгэлийн чанарт анхаарахыг чиглэл болгож ажилласан.

Гадаад харилцаанд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс 2018 оны жилийн эцсийн байдлаар 224 хууль тогтоомжийн 352 зүйл заалтын биелэлт гаргаж байснаас бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тус яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй зэрэг 30 гаруй хууль тогтоомжийн 60 гаруй заалтыг хяналтаас хасуулж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувь хэрэгжсэн **24** заалтыг хяналтаас хасуулах саналыг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д оруулав.

ГХЯ-ны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар гаргасныг хүснэгтээр харуулбал:

№	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр	Шийдвэр тоо	Зүйл, заалтын тоо	Биелэлт хувиар				Үнэлэх боломжгүй /хугацаа болоогүй	Дундаж хувь
				100	70	30	0		
1.	Хууль тогтоомж	2	2	2				100	
2.	Улсын Их хурлын тогтоол	3	4	4				100	
3.	УИХ-ын байнгын хорооны тогтоол	4	7	6	1			95.7	
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2				100	
5.	ҮАБЗ-ийн зөвлөмж	1	4	2	1		1	100	
6.	ҮАБЗ-ийн хуралдааны	23	23	10	6		7	85.0	

	тэмдэглэл								
7.	Засгийн газрын тогтоол	40	57	50	6			1	96.7
8.	Ерөнхий сайдын захирамж	7	7	7					100
9.	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	78	102	73	27			2	82.0
10.	Засгийн газрын албан даалгавар	3	19	13	2			4	91.0
Нийт		162	227	169	43			15	93.92

Тайлангийн хугацаанд УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос баталсан тогтоолуудын хэрэгжилтийг 2019 оны 1, 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн гаргаж тус хороонд 2019 оны 13/2847, 01/6272 тоот албан бичгүүдээр хүргүүлэв.

Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны хэрэгжилтийг танилцуулсаны дагуу дараах зөвлөмжийг гаргаж яамны газар, нэгж, ДТГ-уудад хүргүүлээд байна. Үүнд:

1. Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны хэрэгжилтэд өөрсдийн хариуцсан заалтуудыг газар нэгж бүр улирлаар дүгнэж хариуцсан ажилтнуудыг тогтмол удирдлагаар хангаж ажиллах, хугацаа болоогүй гэсэн үнэлгээтэй байгаа заалтуудын хэрэгжилтэд анхаарч ажиллах;

2. Газар, нэгжийн удирдлагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтад орсон Дээд, өндөр түвшиний болон Засгийн газрын гишүүдийн айлчлал, Засгийн газар хоорондын комиссын хуралдааны төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, хэрэгжилт хангалтгүй байгаа заалтуудыг хэрэгжүүлэх, бусад байгууллага, газрууд хариуцаж буй заалтуудын биелэлтийг хангах чиглэлээр хамтран ажиллах;

3. Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд сүүлийн 3 жил дараалан 70.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн зүйл, заалтуудыг 100.0 хувьд хүргэх.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

“Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд гадаад харилцааны чиглэлээр тусгагдсан тус яам болон бусад яамтай хамтран хэрэгжүүлэх нийт **38** зорилтын **109** ажил, арга хэмжээ тусгагдсанаас ГХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр **64**, хамтран хэрэгжүүлэгчээр **45** ажил, арга хэмжээ хариуцаж байна.

ГХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр хариуцаж буй 64 ажил, арга хэмжээний хэрэгжилт 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дундаж биелэлт **96.13 хувийн** гүйцэтгэлтэй гарсан бөгөөд хэрэгжилтийг танилцуулгын хамт 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13/302 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Хэрэгжилтийн байдлыг ажил, арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувийг хүснэгтээр дор харуулав. Үүнд:

№	Биелэлтийн дүн	Үндсэн хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Ажил, арга хэмжээний тоо
1.	100 хувь (үр дүнтэй)	54	-	54
2.	70 хувь (тодорхой үр дүнд хүрсэн)	8	-	8
3.	40 хувь (эрчимжүүлэх шаардлагатай)	-	-	-
4.	0 хувь (үр дүнгүй)	-	-	-
5.	Үнэлэх боломжгүй	2	45	47
Нийт арга хэмжээний тоо		64	45	109
Хэрэгжилт /хувь/		96.13	-	96.13

Үндсэн хэрэгжүүлэгчээр тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тус бүрээр, хүснэгтээр дор үзүүлэв. Үүнд:

Д/д	Ажил, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ				
	100 хувь	70 хувь	40 хувь	0 хувь	Үнэлэх боломжгүй
1.	2.11.2	4.4.4.5	-	-	2.11.1
2.	4.2.5.4	5.2.6.4	-	-	5.6.10.5
3.	5.2.6.1	5.6.1.9	-	-	-
4.	5.2.6.2	5.6.2.4	-	-	-
5.	5.2.6.3	5.6.6.5	-	-	-
6.	5.6.1.1	5.6.7.4	-	-	-
7.	5.6.1.2	5.6.9.5	-	-	-
8.	5.6.1.3	5.6.10.4	-	-	-
9.	5.6.1.4	-	-	-	-
10.	5.6.1.7	-	-	-	-
11.	5.6.1.10	-	-	-	-
12.	5.6.1.11	-	-	-	-
13.	5.6.1.12	-	-	-	-
14.	5.6.2.1	-	-	-	-
15.	5.6.2.2	-	-	-	-
16.	5.6.2.3	-	-	-	-
17.	5.6.3.1	-	-	-	-
18.	5.6.3.2	-	-	-	-
19.	5.6.3.3	-	-	-	-
20.	5.6.3.4	-	-	-	-
21.	5.6.3.5	-	-	-	-
22.	5.6.3.6	-	-	-	-
23.	5.6.3.7	-	-	-	-
24.	5.6.4.1	-	-	-	-
25.	5.6.4.2	-	-	-	-
26.	5.6.4.3	-	-	-	-
27.	5.6.5.1	-	-	-	-
28.	5.6.6.1	-	-	-	-
29.	5.6.6.2	-	-	-	-
30.	5.6.6.3	-	-	-	-
31.	5.6.6.4	-	-	-	-
32.	5.6.6.7	-	-	-	-
33.	5.6.6.8	-	-	-	-
34.	5.6.7.2	-	-	-	-
35.	5.6.7.3	-	-	-	-

36.	5.6.7.5	-	-	-	-	
37.	5.6.7.6	-	-	-	-	
38.	5.6.8.1	-	-	-	-	
39.	5.6.8.3	-	-	-	-	
40.	5.6.8.4	-	-	-	-	
41.	5.6.9.1	-	-	-	-	
42.	5.6.9.2	-	-	-	-	
43.	5.6.9.3	-	-	-	-	
44.	5.6.9.4	-	-	-	-	
45.	5.6.10.1	-	-	-	-	
46.	5.6.10.2	-	-	-	-	
47.	5.6.11.1	-	-	-	-	
48.	5.6.11.2	-	-	-	-	
49.	5.6.11.3	-	-	-	-	
50.	5.6.12.1	-	-	-	-	
51.	5.6.12.2	-	-	-	-	
52.	5.6.12.3	-	-	-	-	
53.	5.6.12.4	-	-	-	-	
54.	5.6.13.1	-	-	-	-	
Нийт	54	8	-	-	2	64

“Үнэлэх боломжгүй” гэж үнэлэгдсэн дараах 2 ажил, арга хэмжээ байна. Үүнд:

Д/д	Арга хэмжээ	Хүрсэн түвшин, үр дүн
1.	2.11-1. Алтанбулаг чөлөөт бүсийг ОХУ-ын талтай шууд гарцаар холбох асуудлыг судлан шийдвэрлүүлэх	<p>1.Улаанбаатар хотноо 2016 оны 12 дугаар сард хуралдсан Монгол, Оросын ЗГХК-ын 20 дугаар хуралдааны протоколд “ОХУ-ын Хиагт хот, “Алтанбулаг” чөлөөт бүсийг шууд холбох замыг нээх боломжийг судлан саналыг боловсруулж, оросын талд хүргүүлэх” гэж заасны дагуу Оросын талд хүсэлт хүргүүлсэн боловч айлын тал Хиагт боомтод одоогоор авто зам барихаар төлөвлөгдөөгүй гэсэн хариуг ирүүлсэн.</p> <p>2. Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг тэргүүтэй ГХЯ, БХБЯ, “Алтанбулаг” чөлөөт бүсийн захиргаа, Сэлэнгэ аймгийн захиргаа, хилийн хяналтын байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг 2017 оны 1 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Алтанбулаг-Хиагт боомтод ажилласан. Энэ үеэр “Алтанбулаг” чөлөөт бүсийг шууд холбох асуудлыг оросын талд хөндөж тавихад “ОХУ-ын Хиагт боомтын төлөвлөлтийн ёсоор монголын талын хүсэлт болгож буй чиглэлээр зөвхөн зорчигч, хөнгөн тэрэг гарахаар өргөтгөл хийгдсэн тул боломжгүй, одоогийн ачааны машин гарч, орж байгаа хэсгээр оросын талаас “Алтанбулаг” чөлөөт бүстэй холбох ямар ч зай талбай байхгүй, харин Монгол Улсын нутаг дээр зорчигч, ачаа, хөнгөн тэрэгний урсгал, хөдөлгөөнд саад учруулахгүй холбох ажлыг монголын тал өөрсдөө зохион байгуулах нь зүйтэй” гэсэн хариу өгсөн.</p> <p>Алтанбулаг чөлөөт бүсээс ОХУ-ын талтай шууд гарцаар холбох боломжгүйг оросын тал мэдэгдсэн тул уг заалтыг ЗГҮАХ-өөс хасах саналаа ЗГХЭГ-т ГХЯ-наас хүргүүлсэн.</p>
2.	5.6.10-5. Монгол Улсын ололт амжилт, тулгарсан сорилт бэрхшээлүүдийн талаарх	<p>1.Олон улсын хамтын ажиллагааны сан (ОУХАС), Нээлттэй нийгэм хүрээлэнгийн хамтын ажиллагааны хүрээнд олгосон санхүүжилтийн үлдэгдлийг ОУХАС-гийн шугамаар 2018 онд хэрэгжүүлэх олон улсын арга хэмжээнүүдийг зохион байгуулахад зарцуулахаар ГХ-ны сайдын зөвлөлөөс шийдвэрлэсэн.</p> <p>2. Дараах арга хэмжээг Улаанбаатар хотноо зохион байгуулав:</p>

<p>туршлагыг бусад улс орнуудтай хуваалцах зорилго бүхий Олон улсын хамтын ажиллагааны сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>а) “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох асуудал: Монгол Улсын жишээ” олон улсын бага хурал. 2018.4.25. Бага хуралд Афганистан, Бутан, Киргиз, Мьянмар, Лаос, Шри Ланка Улсаас 26, нийт 100 гаруй төлөөлөгч оролцов,</p> <p>б) Олон улсын хамтын ажиллагааны сангийн шугамаар иргэний нийгэм, төрийн бус байгууллагын талаарх Монгол Улсын туршлагыг судлах Лаос Улсын Засгийн газрын төлөөлөгчдийн айлчлалыг Олон улсын Бүгд найрамдахчуудын хүрээлэнтэй хамтран 1 дүгээр сарын 07-11-ний өдрүүдэд Улаанбаатарт зохион байгуулав. Лаос Улсын Засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад ажиллах үеэрээ ГХЯ, ХЗДХЯ, БСШУСЯ, зэрэг төрийн яам, байгууллагын албаны хүмүүсээс гадна иргэний нийгмийн төлөөлөгчидтэй уулзаж санал солилцов.</p> <p>Уг санг татан буулгах шаардлагагүй гэсэн үндэслэлийг удаа дараа Сангийн яаманд явуулсан хэдий ч 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 87 дугаар “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын дагуу тус санг татан буулгах шийдвэр гарсан. Иймд тус сангийн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон.</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Эдгээр ажил, арга хэмжээг айлын талаас болон манай улсын дотоодын нөхцөл байдлаас хамааран хэрэгжих явцад удаашрал гарсан тул “Үнэлэх боломжгүй” гэсэн үнэлгээг өгсөн.

ЗГХЭГ-ын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний тайланд дурдсанаар ГХЯ нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээр 4.08 үнэлгээтэйгээр Төрийн захиргааны төв байгууллагуудаас 3 дугаар байрт эрэмбэлэгдсэн болно.

Энэхүү тайлангаар өгсөн зөвлөмжид 2019 онд “эрчимжүүлэх шаардлагатай” буюу удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан удаашралтай байгаа дараах 3 ажил, арга хэмжээг онцлон дурдсан. Үүнд:

1. 2.11.1. Алтанбулаг чөлөөт бүсийг ОХУ-ын талтай шууд гарцаар холбох асуудлыг судлан шийдвэрлүүлэх;


2. 5.2.6.3. БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг хийж, хэлэлцээрийг байгуулах;

3. 5.6.10.4. Монгол Улсыг олон улсын тавцанд эерэгээр сурталчлан таниулах, “Монгол Улс” брэндийг үүсгэх, имижийг бүрдүүлэх ажлыг эхлүүлэх.

Үүнээс 2.11.1-д тусгагдсан ажил, арга хэмжээг Шадар сайдын ажлын албанд, 5.6.10.4-д тусгагдсан ажил, арга хэмжээг Ерөнхий сайдын дэргэдэх Үндсэний брэндийн бодлогын зөвлөлд тус тус шилжүүлэх тухай саналыг 2019 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 13/2282 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн байдлаар 5.2.6.3, 5.6.10.4-д заасан ажил, арга хэмжээний хувьд 2018 онтой харьцуулбал тодорхой ахиц гаргасан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2016-2019 оны жилийн эцсийн биелэлтийн дүнг харьцуулан харуулав.



Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад харилцааны чиглэлээр туссан ажил, арга хэмжээний 2019 оны хэрэгжилтийг танилцуулсны дагуу дараах зөвлөмжийг өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 2020 онд хэрэгжээд дуусаж байгаа тул зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу 2019 оны жилийн эцсийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байгаа 8 ажил, арга хэмжээнд анхаарч, 2020 оны жилийн эцсийн тайланд хэрэгжилтийг 100 хувьд хүргэхэд анхаарах шаардлагатай болно.

1.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд гадаад харилцааны чиглэлээр нийт 2 зорилтын 6 ажил, арга хэмжээ тусгагдаж, 2019 оны жилийн эцсийн дундаж биелэлт **95.0 хувийн** гүйцэтгэлтэй гарсан. Үндсэн чиглэлийн биелэлтийг танилцуулгын хамт 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13/301 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Биелэлтийн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хэрэгжилтийн хувь
1.	14.7. Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	14.7.1. Шинээр цахимжуулах үйлчилгээний нэр төрөл	14	00.00	100%
2.	19.1. Хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	19.1.1. Замын-Үүд-Эрэний чөлөөт бүс байгуулах ажлын явц, /хувиар/	80	8.3 сая төгрөг /Улсын төсвөөс/	100%
3.	19.2. Монголын бараа,	19.2.1. Яриа	2	00.00	100%

	бүтээгдэхүүнийг зах зээлд таатай нөхцлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг бууруулах	хэлэлцээр хийх орон			
4.	19.3. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	19.3.1. Үйл ажиллагааны хэрэгжилт, /хувиар/	-	127.06	70%
5.	19.4. Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	19.4.1. Шинээр нээж ажиллуулах Ерөнхий консулын газар	2	444.43 Улсын төсөв	100%
6.	19.4. Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор консулын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бэхжүүлэх	19.4.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах дүрэм	1	00.00	100%

ГХЯ нь ЗГХЭГ-аас “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-гаар өгсөн үнэлгээгээр үндсэн чиглэлийн 2018 оны гүйцэтгэлд 3.50 гэсэн үнэлгээтэйгээр төрийн захиргааны төв байгууллагуудаас 9 дүгээрт эрэмбэлэгдсэнд дүгнэлт хийн ажиллаж, 2019 оны гүйцэтгэлийг өмнөх оноос ахиулсан үзүүлэлттэй гарсан.

Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэлд гадаад харилцааны чиглэлээр туссан ажил, арга хэмжээний 2019 оны хэрэгжилтийг танилцуулсаны дагуу дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д гадаад харилцааны чиглэлээр туссан 1 зорилтын 4 ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, зорилт, арга хэмжээний шалгуур, үзүүлэлт, хүрэх түвшинг 2020 оны хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх;

2. Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлийн 2 дахь заалтын 2.1-д “Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх” гэж заасны дагуу ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заахад анхаарч ажиллах.

Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

2.1. Гадаад харилцааны яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 225 ажил, арга хэмжээ тусгагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт өнгөрсөн оны 12 дугаар сарын 31-ний

байдлаар **94.17** хувьтай гарсан бөгөөд хэрэгжилтийг танилцуулгын хамт 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13/304 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. /Хавсралт-1/

Төлөвлөгөөний биелэлтийг дор үзүүлэв.

№	Биелэлтийн дүн хувиар	Төлөвлөсөн ажил, арга хэмжээний тоо
1.	100 хувь (үр дүнтэй)	170
2.	70 хувь (тодорхой үр дүнд хүрсэн)	41
3.	40 хувь (эрчимжүүлэх шаардлагатай)	0
4.	0 хувь (үр дүнгүй)	-
5.	Үнэлэх боломжгүй	14
Нийт арга хэмжээний тоо		225
Хэрэгжилт /хувиар/		94.17

Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд “үнэлэх боломжгүй” ажил, арга хэмжээний тоо өмнөх оныхоос 12-оор багассан байгаа нь төлөвлөгөөний биелэлтэд ахиц гарч байгааг илтгэж байна.

Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанд танилцуулсны дагуу дараах зөвлөмжийг өгсөн болно. Үүнд:

1. 2020 онд “үнэлэх боломжгүй” гэсэн ажил, арга хэмжээний тоог эрс багасгах, улмаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө гүйцэтгэлийн боломжийг сайтар урьдчилан харж төлөвлөх;

2. 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дээд, өндөр хэмжээний айлчлал, зарим арга хэмжээ гаднын хүчин зүйл, хүндэтгэн үзэх шалтгаанаар тухайн онд хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн ажил, арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хугацааг дахин нягтлах, эсхүл төлөвлөгөөнөөс хасаж батлуулах.

2.2. Гадаад харилцааны яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

ГХЯ-ны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2019 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийг дээр дурдсан журмын 10 дугаар хавсралтад дурдсан шалгуур үзүүлэлтээр гаргахад нийт үнэлгээний дундаж хувь 100 хувьтай байна /хавсралт-5/.

Гадаад, дотоодын сургалтын талаарх мэдээллийг тухай бүр яамны нийт албан хаагчдад хүргүүлж, сонгон шалгаруулах замаар 2019 онд магистрын сургалтад /1-2 жил/ 7, дипломатын сургалтад /7-45 хоног/ 41, гадаад худалдааны боловсон хүчнийг бэхжүүлэх сургалтад 25, гадаад хэлний сургалтад /2-6 сар/ 18, орчуулагчийн сургалтад 40 давхардсан тоогоор нийт 131 албан хаагчийг гадаадын богино, дунд, урт хугацааны сургалтуудад, мөн Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Удирдлагын академиас зохион байгуулсан

Тэргүүн түшмэл болон Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтуудад 38 албан хаагчийг хамруулав. Түүнчлэн, ГХЯ-ны нэр дээр ОХУ-ын “Роснефть” компанийн тэтгэлгээр Москвагийн Олон улсын харилцааны их сургууль болон И.М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургуульд суралцах иргэдийн элсэлтийн шалгалтыг Ерөнхийлөгчийн Тамгын газар болон БСШУСЯ-тай хамтран 2019 оны 3 дугаар сард зохион байгуулж, шалгарсан 10 иргэний материалыг ОХУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-аар дамжуулан холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэв.

ТНБД-аар батлуулсан 2019 онд дотоодын сургалтын төлөвлөгөөний дагуу Нийтийн албаны удирдах албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг сургалт, Жендэрийн сургалт, Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх сургалт, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаарх сургалт, Төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалт, орчуулга хийх, орчуулгын онол, арга зүйн чадавхийг дээшлүүлэх сэдэвт сургалт, Монгол Улсын эдийн засаг, нийгэм, гадаад худалдааны өнөөгийн төлөв байдал, ойрын үеийн зорилт, гадаад сурталчилгаа, соёлын харилцааны тухай зэрэг 15 удаагийн сургалтад болон Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Удирдлагын академиас “Төрийн албаны хууль, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах” сэдэвт сургалтад нийт ажилтнуудыг хамруулав. Үүнээс гадна 2019 онд томилолт авсан дипломат, төрийн захиргааны болон үйлчилгээ техникийн ажилтнуудад зориулж тус яамны Консулын газартай хамтран тусгай сургалтын төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж ерөнхий мэдээлэл, үндсэн ойлголтын болон дадлага хийх 21 төрлийн сургалтыг тухайн ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд болон залуу ажилтнуудыг хамруулж, зохион байгуулав.

Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

ГХЯ-ны албан ёсны цахим хуудас /mfa.gov.mn/-д 2019 оны турш нийт 773 мэдээ, мэдээлэл тавигдсан байна. Үүнээс үндсэн үйл явдал цэсэнд 584, ДТГ-аас ирсэн мэдээ цэсэнд 181, зарлал цэсэнд 8, ярилцлага цэсэнд 0, видео цэсэнд 6 ярилцлагыг тус тус байршуулжээ.

Гадаадад ажиллаж амьдарч буй иргэдтэй холбоотой буюу консулын харилцаатай холбоотой мэдээлэл яамны цахим хуудасны консулын мэдээлэл цэсээр дамжин консулын цахим хуудсанд байршиж мэдээг байнга шинэчлэн баяжуулж, гадаад улсад амьдарч буй иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг түгээж ажиллав.

Ил тод байдлын 2019 оны үнэлгээ дунджаар 100 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайланг хавсаргав /хавсралт-3/.

3.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

ХШҮДАГ-аас 2019 онд “Шилэн дансны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.2¹ хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.5², Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2³-д заасны дагуу хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг тухайд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, дараах зөвлөмжийг хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажилласан /хавсралт-4/.

1. ТНБД-ын 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн “ДТГ-ын зохион байгуулалт, дотоод ажлыг сайжруулах, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” 13/01 дүгээр зааварлах захидлын 3 дугаар бүлгийн 9-д “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, уг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд байршуулах хугацааны графикайг чанд мөрдөж ажиллах” -ыг үүрэг болгосон.

2. Сангийн яамнаас 2019 оны 6 дугаар сарын 11-ний 13-1/3881 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах, ДТГ-уудын 2019 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар байршуулаагүй бүх мэдээллийг нөхөн байршуулж, тайлагналтын хугацаанд онцгой анхаарч ажиллаа.

3. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар танилцуулах хуудас 3, мэдээллийн цахим хуудсанд байршуулах зөвлөмж, мэдээллээ бүрэн байршуулах, нөхөж байршуулах тухай хугацаатай үүрэг даалгавар бүхий нийт 7 цахим шууданг ДТГ-уудад хүргүүлэв.

4. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэнд улирал бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийж яамны удирдлагад танилцуулан ТНБД-аас өгсөн чиглэлийн дагуу “С”, “D” үнэлгээтэй ДТГ-уудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж, зааварчилгаа, чиглэлийг цахим шуудангаар хүргүүлэн ажиллав. Тухайлбал: Оттава, Дели.

Үүний үр дүнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 47 байгууллагын дүнгээр 2019 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт **98.31** хувийн гүйцэтгэлтэй, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан мэдээллийн тоогоор 84.52 хувийн чанарын үзүүлэлттэй гарсан.

Тайлангийн хугацаанд нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 3 байгууллага, 42 ДТГ, ТӨБ 1, төслийн 1 байгууллага хамрагдаж нийт 16 төрлийн 7004 /давхардсан тоогоор/ мэдээлэл цахим хуудсанд байршуулахаас 6886 мэдээлэл буюу

¹ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

² шилэн дансны хөтлөлт.

³ Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ.

98.31 хувь байршуулж, үүнээс хуулийн хугацаанд 5903 буюу 84.28 хувь, хугацаа хоцорч 983 буюу 14.03 хувь, 118 буюу 1.68 хувь нь мэдээллээ байршуулаагүй байна.

ДТГ газрууд улирал, хагас жил болон бүтэн жилд оруулах мэдээллийг хугацаанд нь байршуулахгүй хоцроох нийтлэг дутагдал гарч байна. Тухайлбал: дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг үзүүлэлтэд хамаарах мэдээллийг оруулахгүй байна.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалын дагуу үнэлгээ хийхэд хуулийн хугацаанд байршуулсан байдлаар дүгнэхэд “А” буюу “үр дүнтэй” 25, “В” буюу “тодорхой үр дүнд хүрсэн” 15, уг журмын 6.2.1.3-д заасан “эрчимжүүлэх шаардлагатай” /60-с доош хувь/ 6 ДТГ байна.

Гадаад харилцааны салбарын хэмжээний “Шилэн дансны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд 2019 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 98.3 хувийн биелэлттэй, шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуулийн хугацаандаа байршуулсан байдал өмнөх оныхоос 10.53 хувиар өсөж 84.23 хувь, хугацаа хоцролт 10.67 хувиар буурсан, мэдээлэл байршуулаагүй байдал 0.18 хувиар өссөн үзүүлэлттэй, “Шилэн дансны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт **“хангалттай”** биелсэн байна.

3.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Авилгатай тэмцэх газар нь “Авилгын эсрэг хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авилгын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авилгын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) нь тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ (үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн үнэлгээ), дотоод шударга байдлын үнэлгээ (төрийн үйлчилгээг хүргэсэн төрийн албан хаагчдын үнэлгээ), бодлогод оролцогчдын үнэлгээ (шинжээчдийн үнэлгээ) гэсэн гурван дэд үнэлгээнээс бүрдсэн үнэлгээ юм.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээгээр 2019 оны тайланд нийт 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ) тусгаснаас ГХЯ 17 дугаар байрт буюу **76.7** хувьтай байна. Үүнээс нийт 13 яамдын ШБҮ-ээр 2 дугаар байрт тус тус орсон байна.

Өнгөрсөн 2018 оны дүнтэй харьцуулахад 80.2 хувиар 62 байгууллагын 5 дугаарт жагсаж байснаас 12 байр ухарч 17-д орсон нь тус яамны хувьд иргэдийн үнэлгээгээр үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал, албан хаагчдын хариуцлагатай байдлын үнэлгээ өмнөх оноос буурсан гэсэн тайлбартай АТГ-ын албан ёсны цахим хуудаст байршуулсан байна.

3.4. Хэрэглэгчийн үнэлгээ

ГХЯ-ны Консулын газраас чиг үүргийн дагуу иргэдэд үзүүлж байгаа ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, хүнд сурталгүй байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхэд нийт 512 үйлчлүүлэгчийг хамруулсан байна.

Консулын газрын үйлчилгээ болон албан хаагчдын үйл ажиллагааг 5 бүлгийн 34 үзүүлэлтийн хүрээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлоход ГХЯ, Консулын газрын хэрэглэгчийн дундаж үнэлгээ **83.48** хувийн үзүүлэлттэй буюу **“хангалттай сайн”** гэсэн үнэлгээтэй гарчээ.

Хүснэгт 1. Хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ /хувь/	Тайлбар
3.1. Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж хугацаа, буй шат дамжлага, шуурхай байдал	85.3	Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж буй шат дамжлага, шуурхай байдлын түвшинг 1. үйлчилгээний түргэн шуурхай байдал, 2. үйлчилгээний шат дамжлага гэсэн хоёр шалгуураар үнэлүүлж дундаж үнэлгээг гаргавал 85.3 хувийг хангаж байна.
3.2. Үндсэн үйл ажиллагааны чанар, сэтгэл ханамж	80.1	Үйл ажиллагаан чанарыг үнэлэх 12 төрлийн үзүүлэлтээр үнэлүүлж дундаж үнэлгээг гаргавал 4.00 оноо буюу 80.1 хувийг хангаж байна.
3.3. Үйлчилгээний орчны талаарх үнэлгээ	86.0	Үйлчилгээний орчны талаарх үнэлгээг байгууллагын дотоод орчин нөхцөл, байгууллагын гадаад орчин нөхцөл гэсэн хоёр хэсэгт 9 үзүүлэлтээр үнэлүүлж дундаж үнэлгээг гаргавал 4.3 оноо буюу 86.00 хувийг хангаж байна.
3.4. Ажилтуудын харилцааны соёлын талаарх үнэлгээ	85.4	Ажилтан, албан хаагчдын зан харилцаа, ёс зүйн талаарх үнэлгээг 9 үзүүлэлтээр үнэлүүлж дундаж үнэлгээг гаргавал 4.27 оноо буюу 85.4 хувийг хангаж байна.
3.5. Үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	80.6	Үйлчилгээний талаарх мэдээллийн хүрээмжтэй байдлыг мэдээлэл авах суваг, байгууллагын цахим хуудас, мэдээллийн хүртээмж, мэдээллийн чанар зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж гаргахад 4.03 оноо буюу 80.6 хувийн түвшинг хангаж байна.
Нийт 5 багц үзүүлэлтээр үнэлэхэд Консулын газрын хэрэглэгчийн үнэлгээ 83.48 хувийн үзүүлэлттэй буюу "Хангалттай сайн" гэсэн үнэлгээтэй байна.		

Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хавсаргав /хавсралт-6/.

Дөрөв. Дүгнэлт

ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэхэд дараах байдлаар үнэлгээ гарч байна. Үүнд:

1	Үзүүлэлт	Хувь
1	2	3
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	93.92
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	96.1
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	95.0
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	94.17
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.3
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	76.7
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	83.48
Ерөнхий үнэлгээ		93.77